

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ий интернэтийн үйлчилгээний техникийн шаардлага

Интернэтийн үйлчилгээг үзүүлэгч байгууллага нь дараах шаардлагуудыг хангасан байна.

- Интернэтийн гадаад урсгал нь DOWNLOAD/UPLOAD хурд 40 mbps болон түүнээс дээш хурдтай байх
- Dedicated буюу шууд шилэн кабелийн стандартын дагуу холболттой байх
- Олон улсын давхар гарцтай
- Өөрийн мэдлийн IP нэрийн сервертэй /DNS/ -тэй байх
- Гадаад болон дотоод урсгал нь 2 тусдаа шилэн кабелийн шөрмөсөөр байх /гадаад урсгалд лимит хийхэд дотоод урсгал хязгаарлагдахгүй байх/
- IP хаягжилт нь дараалласан 64 хаяг бүхий гадаад IPv4 хаяг байх
- Монгол улс дотор байршуулсан вэб хуудсуудад хурдны хязгааргүй ханддаг байх
- Интернэтийн үйлчилгээг зогсоох, таслах зэрэг үйлдэл хийхээс 24-48 цагийн өмнө урьдчилан албан бичиг болон цахим шуудангаар мэдэгддэг байх
- 24 цагийн техник үйлчилгээний ажилтантай байх, оператор үйлчилгээгээр дамждаггүй байх
- 24 цагийн автоматжуулсан мониторинг, хяналтын системтэй байх
- Олон улсын стандартад нийцсэн нууцлал хамгаалалтын системтэй байх
- Гаднаас ирэх халдлагаас хамгаалах хамгаалалтын системтэй байх
- Нөөц холболт хийх боломжтой байх - Редундант /Төмөр замын дохиолол холбооны 2-р ангитай холбогдох/
- Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэжлийн инженерийн зөвөлгөө, тусламж өгдөг, хамтран ажилладаг байх

Байгууллагад зориулсан нэмэлт үйлчилгээ урамшуулал нь давуу тал болно